



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ТУШААЛ

2018 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/29

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай 289 дүгээр зүйлийн 289.5 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн алба хаах хугацааг сунгах журам"-ыг хавсралтаар баталсугай.

2. Энэ журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга /бригадын генерал Ц.Амгаланбаяр/-д, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Г.Баясгалан/-д тус тус даалгасугай.



Ц.НЯМДОРЖ

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018  
оны 12 дугаар сарын 15-ны өдрийн  
1/29 дугаар тушаалын хавсралт

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН  
АЛБА ХААГЧИЙН АЛБА ХААХ ХУГАЦААГ  
СУНГАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэ журмын зорилго нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 289 дүгээр зүйлийн 289.1 дэх хэсэгт заасан насны дээд хязгаарт хүрсэн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн алба хаах хугацааг сунгахтай холбоотой харилцааг зохион байгуулна.

1.2. Энэ журам нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм, журамтай нийцсэн байна.

Хоёр. Алба хаагчийн алба хаах хугацааг сунгах

2.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч нь алба хаах насны дээд хязгаарт хүрсэн боловч хуульд заасан үндэслэл, журмын дагуу дахин нэг жилээр сунгуулах тухай өргөдлөө шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын даргад гаргана.

2.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага нь алба хаах хугацаа сунгуулахаар гаргасан алба хаагчдын хүсэлтийг нэгтгэж, тухай бүр нь хууль зүйн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүнд ирүүлнэ.

2.3. Алба хаах хугацаа сунгуулахаар ирүүлсэн алба хаагчдын материалыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар хуулийн хугацаанд хянаж, шаардлагатай гэж үзсэн алба хаагчдын алба хаах хугацааг 1 жилээр сунгуулах шийдвэр гаргуулна.

2.4. Алба хаах хугацааг сунгасан алба хаагчдын нэрсийн жагсаалтыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагад хүргүүлнэ.

2.5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага нь алба хаах хугацааг дахин нэг жилээр сунгасан болон алба хаах хугацааг сунгаагүй тухай шийдвэрийг алба хаагч бүрт мэдэгдэнэ.

Гурав. Алба хаах хугацаа сунгуулахад шаардагдах материал

3.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад алба хаах хугацаа сунгуулах хүсэлт гаргасан алба хаагч нь дараахь шалгуур үзүүлэлтийг хангана.

3.1.1. эрүүл мэндийн тодорхойлолт;

3.1.2. сүүлийн 3 жилийн үйл ажиллагааны тайлан, үр дүн, мэргэжлийн түвшингийн үнэлгээ нь "В" буюу түүнээс дээш байх;

3.1.3. шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад мэргэшсэн байдал ажлын дадлага туршлагатай байх;

3.1.4. ёс зүйн зөрчил гаргаагүй байх;

3.1.5 төрийн албан хаагчийн анкет, шаардлагатай тохиолдолд их, дээд сургууль болон тухайн чиглэлээр төгссөн курс, дамжаа төгссөн диплом, гэрчилгээний хуулбар байна.

3.2. Энэ журмын 3.1-д заасан шалгуур үзүүлэлтийг хангаагүй тохиолдолд алба хаах хугацааг сунгахгүй.

3.3. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага нь алба хаах хугацаа сунгуулахаар ирүүлсэн алба хаагчийг тус байгууллагад үргэлжлүүлэн ажиллуулах тухай санал, тодорхойлолтыг хүн тус бүрээр ирүүлнэ.

#### Дөрөв. Алба хаагчийг цэргийн тэтгэвэрт гаргах

4.1. Алба хаагч нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 289 дүгээр зүйлийн 289.3 дахь хэсэгт заасан хугацаанд алба хаах хугацааг дахин нэг жилээр сунгуулах тухай хүсэлтээ гаргаагүй бол алба хаах насны дээд хягаар хүрснээс хойш 3 сарын дотор шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга тухайн алба хаагчийг цэргийн тэтгэвэрт гаргах тухай шийдвэр гаргана.

4.2. Энэ журмын 4.1-д заасан хугацаанд цэргийн тэтгэвэрт гаргахдаа түүнд энэ талаар мэдэгдэл хүргүүлж, холбогдох материал бүрдүүлэх нөхцөлөөр хангана.

4.3. Алба хаагч нь Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацаанд алба хаасан бол гагцхүү өөрийн хүсэлтээр цэргийн алба хаасны тэтгэвэрт гарах эрхтэй байна.

4.4. Алба хаагчийг цэргийн алба хаасны болон өндөр насны тэтгэвэрт гарахад нь түүнийг тухайн ажиллаж байсан байгууллагаас албан ёсоор хүндэтгэл үзүүлнэ.

#### Тав. Санхүүжилт

5.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын дарга нь тухайн жилд цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгох алба хаагчдын судалгааг нэгтгэн Төсвийн тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчид хугацаанд нь ирүүлсэн байна.

#### Зургаа. Бусад зүйл

6.1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага алба хаах хугацаа сунгуулахаар ирүүлсэн алба хаагчид холбогдох нэмэлт материалыг саадгүй гарган өгөх үүрэгтэй бөгөөд хуурамч баримт бичиг бүрдүүлж өгөхийг хориглоно.

6.2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллага нь алба хаах хугацаа сунгуулахтай холбоотой хүний нөөцийн нэгдсэн сан хөтөлж, тухай бүрт нь хувийн хэрэгт баяжилт хийнэ.

6.3. Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд хууль тогтоомжийн хүрээнд хариуцлага тооцно.